

ДААТГАЛЫН НӨХЦӨЛ

2022-2023



2022-2023 ДААТГАЛЫН НӨХЦӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

“Энэхүү нөхцөл нь “Ландбридж” ХХК, “Эйрбридж Экспресс” ХХК болон “Эл Би Карго” ХХК-ийн Даатгагчтай байгуулсан даатгалын гэрээний дагуу санал болгож буй нөхцөл бөгөөд “Ландбридж” ХХК, “Эйрбридж Экспресс” ХХК болон “Эл Би Карго” ХХК-иар дамжуулан тээвэрлэгдэж буй ачаа, бараанд учирч болох эрсдэлийг хамгаалах”

2. ДААТГАГЧ

Агула даатгал ХХК

3. ДААТГУУЛАГЧ

/Тухайн гэрээ хийж буй харилцагч байгууллага, хувь хүн/

4. ДААТГАЛЫН ЗҮЙЛ

Тээвэрлэгдэж буй ачаа, бараа

5. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

Даатгал нь 2022 оны 11 сарын 01-ний өдрийн 00:00 цагаас 2023 оны 10 сарын 31-ний өдрийн 23:59 цагийг хүртэлх хугацаанд ачигдсан ачаа, бараа

6. ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ

Гаалийн бүрдүүлэлт хийгдсэн нэхэмжлэхийн дүн, нэг удаагийн тээврийн зардлын нийлбэр

7. НЭГ УДААГИЙН ТОХИОЛДЛООР ОЛГОХ НӨХӨН ТӨЛБӨР

Нэг удаагийн тээвэрлэлтийн буюу нэг удаагийн тохиолдлоор нөхөн төлбөр олгох дээд хэмжээ 5.000.000.000 /Таван тэрбум төгрөг/ байна

Дараах тохиолдлуудад давхар даатгалын хориг цуцлагдах хүртэл нэг удаагийн нөхөн төлбөр олгох дээд хэмжээ тус бүр 100'000'000 /нэг зуун сая/ төгрөг байна.

7.1 Хүлээн авагч, захиалагч, нийлүүлэгч, тээвэрлэгч, илгээгч болон эцсийн өмчлөгч нь ОХУ-ын нутаг дэвсгэрт байрладаг, байнгын оршин суудаг, ОХУ-ын иргэн, ОХУ-ын бүртгэлтэй ААН байгууллага болон ОХУ-ын нутаг дэвсгэрт учирсан хохирол;
7.2 Хөлдөөсөн загас;

8. ДААТГУУЛАГЧИЙН ХАРИУЦАХ ХЭСЭГ

8.1 Даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын хэмжээ 10% байх ба нэг удаагийн тохиолдлоор олгохоор тооцсон нөхөн төлбөрөөс хасч олгоно;

9. ЗУУЧЛАГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН НӨХЦӨЛ

9.1 Зуучлагч нь “Тээвэр зуучийн үйлчилгээ”-г үйлчлүүлэгчиддээ үзүүлэх явцдаа зуучлагч, түүний эрх бүхий ажилтны санамсаргүй үйлдэл, эс үйлдэхүйн алдаанаас үүдсэн үйлчлүүлэгчийн ачааг дахин тээвэрлэх, тээвэр зохион байгуулахтай холбоотой хадгалалтын зардлын хохирол;

9.2 Зуучлагчийн үндсэн ажилтны гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээг үзүүлэх явцдаа санамсар болгоомжгүйн улмаас алдаа гарган хохирол учруулах;

9.3 Зуучлагчийн үндсэн ажилтны гаалийн хяналтын талбайд ачааг ачих, буулгах, хүлээлгэж өгөх үйл ажиллагаанд санамсар болгоомжгүй буруутай үйл ажиллагаа гаргаж захиалагчийн ачаа бараанд хохирол учруулах;

9.4 Гаалийн баталгаат талбайгаас харилцагчийн эзэмшлийн талбайд Зуучлагчийн өөрийн болон гэрээт тээврийн хэрэгслээр хүргэх үед гарах зам тээврийн ослоос үүдэлтэй эрсдэлүүд;

9.5 Зуучлагчийн үндсэн ажилтны зохион байгуулсан экспортын тээвэрт санамсар болгоомжгүйн улмаас гаалийн хяналтын талбай болон агуулахад тухайн ачаа барааны ачилт бэхлэгээг стандартын дагуу шаардлага хангаагүй хийснээс үүдэн захиалагчийн ачаа бараанд хохирол учруулах;

9.6 Зуучлагчийн үндсэн ажилтан санамсар болгоомжгүй буруутай үйлдэл болон эс үйлдэхүйн алдаанаас үүдэн захиалагчийн ачаа бараа хураагдсан тохиолдолд ачаа, барааны хохирлыг төлөх зэрэг эрсдэлүүд багтана.

10. ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

10.1 Даатгалын тохиолдол бий болсон үед даатгагчид 24 цагийн /99905892, 80101096, 88856665/ дотор нэн даруй мэдэгдэн гэрээ болон даатгалын нөхцөлд тусгагдсан баримт материалыг даатгагчид бүрэн гүйцэд хууль зүйн дагуу бүрдүүлэн, даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор бүрэн хүлээлгэн өгөх;

10.2 Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирсан хохирлын шалтгаан нөхцөл, хэмжээг үнэн зөв тогтоохын тулд хууль, хяналтын байгууллага, цагдаа, галын байгууллага, эмнэлэг, хөндлөнгийн үнэлгээний байгууллага зэрэг мэргэжлийн холбогдох байгууллагаар шалгуулж акт, дүгнэлт тогтоолгох;

10.3 Даатгуулагч нь өөрийн санаачлагаар даатгалын тохиолдлоос үүдэлтэй шинжээч томилох нөхцөлд

түүнтэй холбогдох зардлыг даатгуулагч хариуцан нөхөн төлөх үүрэгтэй.

10.4 Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш шинээр бий болсон нөхцөл байдал, эрсдэлийн орчны өөрчлөлт, даатгалын тохиолдол бий болох боломжтой нөхцөл орчин бүрдсэн тухай даатгагчид нэн даруй мэдээлэх;

10.5 Даатгалын тохиолдол болсон үед даатгалын зүйлийг аюулаас зайлуулах, хадгалж хамгаалах, хор хөнөөлийг бууруулах талаар боломжит арга хэмжээг цаг алдалгүй авах;

10.6 Даатгалын жилийн ерөнхий гэрээнээс өөр нөхцөлөөр даатгуулахыг хүссэн тохиолдолд даатгуулагч нь даатгагчтай зөвшилцөн тусгайлан шинээр нэг удаагийн даатгалын гэрээ байгуулна.

11. ДААТГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

11.1 Даатгалын зүйлийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж танилцах;

11.2 Даатгуулагч аюулыг санаатайгаар ихэсгэсэн бол даатгагч гэрээг цуцлах саналыг нөгөө талд тавих;

11.3 Даатгалтай холбоотой шаардлагатай гэж үзсэн мэдээллийг даатгуулагчаас бүрэн хэмжээгээр гаргуулах;

11.4 Даатгуулагч нь даатгалын нөхөн төлбөр авах зорилгоор нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн, бүрдүүлсэн бол даатгагчаас гэрээг цуцалж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр баримтыг хуулийн байгууллагад шилжүүлнэ.

11.5 Даатгалын тохиолдол бий болсон тохиолдолд түүний шалтгаан, нөхцөлийг судлах, эрх бүхий байгууллагаар шалгуулах, шаардлагатай мэдээ, мэдээллийг Даатгуулагчаас шаардах;

12. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ

12.1 Хөлөг онгоц хайрагдах, живэх, хөмрөх, агаарын хөлөг унах;

12.2 Газраар явагч тээврийн хэрэгсэл хөмрөх, онхолдох, замаас гарах, хөмрөх, галт тэрэг замаасаа гарч онхолдох;

12.3 Усан онгоц болон бусад төрлийн тээврийн хэрэгсэл хоорондоо эсвэл усан дээрх зүйлтэй мөргөлдөх шүргэлцэх;

12.4 Тээврийн хэрэгслээс бусад зүйлтэй (объекттой) мөргөлдөх. (Усан тээврээс бусад тохиолдол);

12.5 Онгоцны буудал дээр барааг албан хүчээр буулгах;

12.6 Бүх төрлийн гал түймэр болон дэлбэрэлт;

12.7 Газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт мөн аянгад

цохиулах, үер, далайн шуурга, хуй салхи, ширүүн том хэмжээний мөндөр;

12.8 Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдэл;

12.9 Хулгай, дээрэм, халдлага, далайн дээрэм, хорлон сүйтгэх ажиллагаа;

12.10 Ерөнхий дундаж (general average);

12.11 Хөлгийн тавцангаас барааг зайлшгүй тохиолдлын улмаас хаях (jettison);

12.12 Хөлгийн тавцангаас бараа усанд цохигдон унах;

12.13 Далайн дээрэм;

12.14 Барааг ачих болон буулгах үед алдагдах (Зөвхөн бараа бүтнээрээ алдагдсан тохиолдолд);

12.15 Хөлөг онгоц, чингэлэг бүхий тээврийн хэрэгсэл, вагон, агуулах руу далай, тэнгис, гол, бороо, үерийн ус нэвтрэн орох;

12.16 Биет ачаанд учирч болох дээр дурдагдаагүй бусад эрсдэл;

13. НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТУСГАЙ НӨХЦӨЛ

13.1 Бүрэн сүйрлийн үед: Даатгалын барааны өртөг болон тээврийн зардлын хэмжээгээр олгохоор тооцсон нөхөн төлбөрийг олгоно.

13.2 Хэсэгчилсэн сүйрлийн үед: Даатгалын зүйлд учирсан сүйрлийн тогтоогдсон хувиар даатгалын нийт үнэлгээнээс олгохоор тооцсон нөхөн төлбөрийг тогтооно.

13.3 Хэрэв даатгалын зүйл бүхэлдээ хулгайд алдагдсан талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлснээс хойш даатгалын зүйл олдолгүй 45 хоног өнгөрсөн бол даатгуулагч нөхөн төлбөрийн нэхэмжлэлээ даатгагчид гаргана. Хэрэв 45 хоногийн хугацаанд олоходоо хэсэгчлэн хохирол учирсан байдалтай олдсон бол олдсон тухайн үеэс даатгуулагчид нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах эрх үүснэ.

13.4 Даатгагчтай тохиролцолгүйгээр даатгалын зүйлийг нөхөн сэргээсэн зардал нь нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох үндэслэл болохгүй.

13.5 Даатгалын зүйл бүрэн сүйрсэн гэж үзэж даатгагч нь даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчид олгосон тохиолдолд тухайн сүйрсэн даатгалын зүйлийн өмчлөх эрхийг даатгагчид шилжүүлнэ.

13.6 Даатгагчийн нөхөн төлбөр хариуцсан ажилтан нөхөн төлбөрийн баримтуудыг бүрэн гэж хүлээн авч, зохих баримт үйлдсэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор энэхүү гэрээгээр тохиролцсон хэмжээнд олгоно. Хэрэв даатгагч нь даатгалын нөхөн төлбөр хүссэн баримт бичгийг хянах явцад нэмэлт мэдээлэл цуглуулах,

төрийн эрх бүхий байгууллагаар шалгуулах шаардлага гарсан тохиолдолд энэхүү хугацааг даатгуулагчтай зөвшилцөж сунгаж болно.

13.7 Хэрэв даатгалын нөхөн төлбөртэй холбоотойгоор тухайн хэрэг төрийн захиргааны байгууллагад хянагдаж байгаа, шүүхийн журмаар хянан хэлэлцэгдэж байгаа бол тухайн процессын дагуу хугацаа сунгагдаж болно.

13.8 Даатгалын тохиолдол бий болсны дараа даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

13.9 Даатгалын нөхөн төлбөрийг зохих журмын дагуу даатгуулагчид олгох бөгөөд олгосноос хойш Даатгуулагч гарсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн болох нь тогтоогдсон тохиолдолд Даатгуулагч нь олгогдсон нөхөн төлбөрийг үл маргах журмаар Даатгагчид бүрэн буцаан төлнө.

13.10 Даатгагчийн хүлээх хариуцлага нь бүхлээрээ буюу хэсэгчлэн өөр даатгалын гэрээгээр даатгагдсан бол нөхөн төлбөр нь хүчин төгөлдөр буй бүх даатгалын гэрээнүүдийн хариуцлагын дээд хязгаарын нийлбэр дүнд даатгагчийн хүлээх хариуцлагын эзлэх хувиар даатгуулсан хариуцлагын хязгаараас тооцож олгоно.

13.11 Бүх нөхцөлд нөхөн төлбөрийг даатгалын үнэлгээнд багтаан нэхэмжлэлийн дагуу гэрээнд үндэслэн олгоно. Энэхүү олгохоор шийдсэн нөхөн төлбөрийн дүнгээс ААНОАТ Хуульд заасан 10 хувийн татварыг суутган тайлагнана.

13.12 Даатгалын зүйлийн ашиглаж болох үлдэх хэсгийн өртгийг олгохоор тооцсон нөхөн төлбөрөөс хасч олгоно. Эсхүл даатгалын нөхөн төлбөр олгогдсон зүйлийн үлдэх хэсэг нь даатгагчийн өмч болно. Тухайн нөхөн төлбөр олгогдсон даатгалын зүйлийн үлдэх хэсгийг даатгуулагч нь даатгагчид хүлээлцэх үүрэгтэй ба хүлээлцэх хүртэлх зардлыг Даатгуулагч хариуцахгүй.

14. ДААТГАЛД ХАМААРАХГҮЙ НӨХЦӨЛ

Даатгуулагчийн доорх үйлдэлтэй холбоотой нөхцөлүүд

14.1 Даатгалын зүйлийг зориулалтын бус, тохиромжгүй тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн, мөн зориулалтын бус чингэлэг, хайрцаг сав, агуулахад агуулсан;

14.2 Хуулийн дагуу болон эрх бүхий байгууллагад битүүмжлэгдэх, улсын өмчид шилжүүлэгдэх, шүүхийн шийдвэрээр бусдад хураагдах, шилжсэнээс үүссэн хохирол;

14.3 Бизнес тасалдлаас үүдэн гарсан аливаа санхүүгийн алдагдал, хохирол;

14.4 Тухайн ачааны холбогдох бичиг баримтад хайхрамжгүй хандан, гаалийн бүрдүүлэлтийг хийж чадаагүйгээс үүдэн гарсан хохирол;

14.5 Даатгуулагч даатгалын гэрээгээр болон холбогдох

хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирол;

Даатгалын зүйлийн онцлог болон сав баглаа боодолтой холбоотой нөхцөлүүд:

14.6 Даатгалын зүйлийн хэвийн хорогдол, элэгдэл, ууршилт, алдагдал, жин хэмжээний багасалт, агшилт, нэвчилт, зэврэлт, өнгө алдалт;

14.7 Гадны нөлөөлөлгүйгээр даатгалын зүйл өөрийгөө устгах, шинж чанараа алдах, тээвэрлэлтийн явцад агаарын температурын огцом өөрчлөлтөөс шалтгаалж ачааны шинж чанар өөрчлөгдөх, түүнээс үүдэх хохирол;

14.8 Даатгалын зүйлийн хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдах, зөрчих, бүтээгдэхүүний хугацаа хэтрэх, үйлдвэрлэлийн гэмтэл, гологдол;

14.9 Бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошго, хамгаалалтын болон зөөх зориулалтаар хийгдсэн гадны нөлөөнөөс хамгаалсан сав баглаа боодол гэмтэх;

14.10 Даатгалын бус тохиолдлоор даатгалын зүйлийн хамгаалалтын болон зөөх зориулалтаар хийгдсэн гадны нөлөөнөөс хамгаалсан сав баглаа боодол гэмтсэнээс даатгалын зүйлд хохирол учрахад;

Тээвэрлэгч болон тээвэрлэлттэй холбоотой нөхцөлүүд:

14.11 Тээвэрлэлтийн хугацаа хоцрох, тээвэрлэлт саатах, түүнээс үүдэлтэй хохирол, тээвэрлэлтийн явцыг саатуулж болох тээвэрлэгчийн төлбөрийн чадвар муудалт, санхүүгийн хүндрэл;

14.13 Тээвэрлэлт хийхдээ тухайн тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой тухайн улсын болон олон улсын замын хөдөлгөөний тухайн хууль, дүрэм, журам болон олон улсын гэрээ, конвенцыг баримтлаагүйгээс үүдэн гарсан хохирол;

14.14 Даатгуулагчийн болон түүний ажилтны буруутай үйл ажиллагааны улмаас болон захиалагчийн захиалга буруу өгсөн, буруу мэдээлэл өгсөн зэргээс үүдсэн ачаа хадгалалтын зардал гарсан тохиолдолд тухайн зардал болон зардалтай холбоотой бүх төрлийн торгууль, хүү, алданги;

14.15 Цаг хугацаа, температур, улирлын шинжтэй бүтээгдэхүүний тус онцлогийг харгалзалгүй тээвэрлэсэн буюу тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, чингэлэг зэргийг ашиглаагүй, өөр хоорондоо харшлах ачаа, бүтээгдэхүүнүүдийг хамтад нь тээвэрлэсэн, зориулалтын тээврийн хэрэгслийг ашигласан боловч дээр дурдсан нөхцөлүүдийг хангаагүй, үйлдвэрлэгчээс өгсөн заавар, сануулгыг баримтлаагүй, тус бүтээгдэхүүнийг тээвэрлэх тухай Монгол улсын болон олон улсын стандарт шаардлага хангаагүй тээвэрлэсэн, тээврийн хэрэгслийг унтраасан, тухайн ачааны холбогдох бичиг баримтад хайхрамжгүй хандан, гаалийн бүрдүүлэлтийг хийж чадаагүйгээс үүдэн гарсан хохирол;

Нийгмийн шинжтэй нөхцөлүүд:

14.15 Дайн, бослого, үймээн, эсэргүүцэл, террорист үйл ажиллагаа, ажил хаялт, олзлох, булаах, саатуулах, хорих далайн дээрэм (далайн дээрэм нь А нөхцөлд хамаарахгүй) зэрэг үйлдэл;

14.16 Торпед, дэлбэлэгч цэнэг, бөмбөг болон дайны хаягдсан зэвсгүүд мөн атомын болон цөмийн задрал, нэгдэл, түүнтэй төстэй урвал, цацраг идэвхт хүч ашигладаг зэвсэг, төхөөрөмжийн хэрэглээнээс үүдсэн шууд болон шууд бус хохирол, зардал;

14.17 Боловсруулах үйлдвэр, газрын тос/хийн өрөмдлөгийн байгууламж, газрын тосны талбай, дамжуулах хоолой, насосын станц, цахилгаан станцын байгууламж, бүх энерги болон нефттэй холбоотой химийн эрсдлүүд;

14.18 Салют, сум, тэсэрч дэлбэрэх бодис, газрын тосны бүтээгдэхүүн, хийг шахмал эсвэл шингэрүүлсэн хэлбэртэй бүтээгдэхүүн;

14.19 Хуулийн дагуу битүүмжлэгдэх, хураагдах, улсын өмчид шилжүүлэгдэх, шүүхийн шийдвэрээр бусдад хураагдах, шилжсэнээс үүссэн хохирол;

Онцгой нөхцөлүүд:

14.20 Электрон болон механик эвдрэлээс шалтгаалсан хохирол, мөн даатгагдаагүй эрсдэлээс үүдсэн хохирол;

Газар зүйн нөхцөлүүд

14.21 Доорх бүс нутаг, улс орнуудруу тээвэрлэсэн болон тэндээс тээвэрлүүлсэн аливаа ачаа бараа, эсхүл эдгээр улс орнуудыг дамжин өнгөрөхөд учирсан хохирол;

14.22 Зүүн Африк, баруун Африк, төв Африк, өмнөд Африк;

14.23 Олон улсын Ачаа Тээврийн Нэгдсэн Хороо (JCC-Joint Cargo Committee)-с зарладаг жагсаалтад эрсдэл өндөр, илүү өндөр, онцгой өндөр, маш өндөр (high, very high, severe, extreme) зэрэглэлийн эрсдэлтэй гэж тусгагдсан улс орнууд;

Бусад

14.24 Гуравдагч этгээдийн улс төр, үзэл санаа, шашны, танхайн сэдэлтэй үйлдэл;

14.25 Хүрээлэн буй орчинд, тээвэрлүүлж буй тээврийн хэрэгсэлд болон гуравдагч этгээдэд учруулсан хохирол;

14.26 Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлийн зөвшөөрөгдсөн байршил өөрчлөгдсөн, бусдад барьцаалуулах, түрээслэх, зээлдүүлэх, болон ашиглуулах үед гарсан хохирол;

14.27 Даатгалын тохиолдлоос үүдсэн эдийн засгийн хохирол;

14.28 Даатгалын зүйлийг засварлах зардал нь тухайн зүйлийн өөрийн үнээс давсан хэсгийг;

14.29 Гаалийн үйл ажиллагаатай холбоотойгоор төлөгдсөн болон төлөх бүхий л татвар хураамж, НӨАТ нь даатгалын эрсдэлд хамаарахгүй учир нөхөн төлбөр олгохгүй. Харин ачаанд бүрэн сүйрэл учирч зайлшгүй авран хамгаалахтай холбоотойгоор дээрх гаалийн татвар хураамж төлөх тохиолдолд даатгагчтай заавал зөвшилцөх бөгөөд энэхүү ажиллагаа хийгдээгүй, даатгагчтай зөвшилцөлгүй төлсөн тохиолдолд холбогдох зардлыг;

14.30 Илгээгчээс ачааг дутуу илгээсэн;

14.31 Ачаа барааг тээвэрлэхтэй холбоотой стандарт, дүрэм журам мөрдөөгүй, шаардлага хангаагүй чингэлэг, тээврийн хэрэгсэл, ачаа барааны сав баглаа боодол, хамгаалалтын болон зөөх зориулалттай хийгдсэн сав, ачааны бэхэлгээ зэргийг үйлдвэрлэгч болон тээвэрлэгчээс өгсөн заавар, сануулга болон түүнтэй холбоотой тээвэрлэхэд зориулагдсан Монгол улсын болон олон улсын гэрээ, стандартын шаардлага хангаагүй, хийгдээгүйгээс үүдэн гарсан хохирол;

14.32 Илгээгч ачилт бэхэлгээ хийсэн битүү чингэлэг, битүү бүхээгтэй ачааны гэрэг, битүү тээврийн хэрэгслээр тээвэрлэгдэж буй ачааны хувьд тээвэрлэлтийн явцад гарсан ачилт бэхэлгээнээс үүдэлтэй бүхий л эрсдэл, хохирлыг;

14.33 Учирсан хохирлоос улбаатай ирээдүйд үүсэж болох эрсдлүүд;

14.34 Даатгуулагч нь энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол нөхөн төлбөр олгохгүй;

14.35 30-аас дээш жилийн насжилттай усан онгоцонд ачаа тээвэрлэх. Гэвч давхар даатгалын зөвхөн ICC "С" нөхцлийн дагуу ашиглалтын хугацаа нь 30 жилээс их боловч 35 жилээс доош усан онгоцонд тээвэрлэх ачаа тээврийг даатгаж болно.

14.36 Европын холбоо эсвэл НҮБ-ын тавьсан хоригийг эсэргүүцэж буй үйл ажиллагаа;

14.37 Шимэгч, мэрэгч амьтан, хорхой шавьжнаас үүдэлтэй хохирол;

14.38 Далайд аялах боломжгүй тээврийн хэрэгслээр /сал г.м/ тээвэрлэсэнээс үүдсэн хохирол;

14.39 Ачааны баглаа боодол, тэмдэглэгээ болон бэхэлгээний хангалтгүй байдлаас болж ачаа, тээвэрт үүсэх хохирол;

15. ДААТГАХГҮЙ АЧАА

Гадаад ачаа тээврийн даатгал

15.1 Бүх төрлийн хариуцлагын даатгал;

15.2 Мөнгөн тэмдэгтүүд, хувьцаа, бонд;

- 15.3 Тэжээвэр болон зэрлэг мал амьтад;
- 15.4 Амьд мал, амьтан;
- 15.5 Тэсэрч дэлбэрэх бодис, хориотой бараа;
- 15.6 Сав баглаа, чингэлэг;
- 15.7 Эрдэнэсийн зүйлс, түүхийн дурсгалт зүйлс, археологийн олдвор;
- 15.8 Албан бичиг, тамга, тэмдэг;
- 15.9 Үнэт эдлэл, үнэт цаас, урлагийн бүтээлийн даатгал;
- 15.10 ICC-A&B-д заасан джут, копр, хөвөн;
- 15.11 Үслэг эдлэл болон үнэт эдлэл;
- 15.12 ICC-A&B-д заасан жимс жимсгэнэ болон ногоонд тээвэрлэлтийн хугацаанаас үүдэн ачаа өөрөө өөрийгөө устгасан тохиолдол;
- 15.13 Загасны хоол;
- 15.14 Цемент ;

Тээвэр зуучлагчийн хариуцлагын даатгал

- 15.15 Бэлэн мөнгө, Хувьцаа, бонд, Эрдэнэсийн зүйлс;
- 15.16 Амьтан;
- 15.17 Албан бичиг, Тамга тэмдэг;
- 15.18 Хориотой ачаа, бараа;
- 15.19 Салют, тэсрэх сум, шахмал болон шингэн байдалтай тэсэрч дэлбэрэх;
- 15.20 Тээвэрлэлт хийхдээ тухайн тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой тухайн улсын болон олон улсын замын хөдөлгөөний тухайн хууль, дүрэм, журам болон олон улсын гэрээ, конвенцыг баримтлаагүйгээс үүдэн гарсан хохирол;
- 15.21 Гаалийн болон бусад тагвар ногдуулж барагдуулахтай холбоотой зардал, төлбөр;
- 15.22 Түргэн муудах хүнсний бүтээгдэхүүнийг стандарт, зориулалтын бус тээврээр тээвэрлэсэн ачаа барааны хохирол;

16. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХООС ТАТГАЛЗАХ НӨХЦӨЛ

- 16.1 Санаатай болон хууль бус үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирол;
- 16.2 Эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, захиргааны шийтгэл;
- 16.3 Даатгалын тохиолдол болсныг нотлох боломжгүй, сэргээн засварласан;

16.4 Олон улсын Ачаа Тээврийн Нэгдсэн Хороо (JCC-Joint Cargo Committee)-с зарладаг жагсаалтад эрсдэл өндөр, илүү өндөр, онцгой өндөр, маш өндөр (high, very high, severe, extreme) зэрэглэлийн эрсдэлтэй гэж тусгагдсан улс орнууд;

16.5 Даатгуулагчийн харилцагч, үйлчлүүлэгч буюу ачаа тээвэрлүүлэх гэрээ байгуулсан этгээдийн буруугаас гарсан аливаа зардал;

16.6 Тээврийн хэрэгсэл, техник тоног, төхөөрөмжийн ашиглалтын горим, зааврыг зөрчсөн, даац, ачаалал хэтрүүлснээс үүссэн хохирол;

16.7 Гуравдагч этгээдийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хадгалалтын горим, хугацаа зөрчигдсөний улмаас ачаанд хохирол учрах болон үйлдвэрийн гэмтэл гологдлоос үүдсэн хохирол;

16.8 Даатгуулагчийн зааврын дагуу, стандартын дагуу бэхэлгээ сав, баглаа боодлыг хийгээгүйгээс үүдсэн хохирол;

16.9 Хамгаалалтын болон зөөх зориулалтаар хийгдсэн гадны нөлөөнөөс хамгаалсан сав баглаа боодол гэмтэхэд;

16.10 Бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошго, хамгаалалтын болон зөөх зориулалтаар хийгдсэн гадны нөлөөнөөс хамгаалсан сав баглаа боодол гэмтэх;

16.11 Холбогдох мэргэжлийн байгууллагад учирсан хохирлын талаа газар дээр нь мэдэгдэж үзлэг шалгалт хийлгэн акт дүгнэлт гаргуулаагүй, гэрээнд заасан хугацаанд хохиролтой холбоотой материалыг даатгагчид мэдүүлээгүй;

16.12 Ажил үүргээ гүйцэтгэж байхдаа эрх зүйн чадамжгүй байсан эсвэл согтууруулах ундаа, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэсэн үед үүдэн гарсан хохирол;

16.13 Гэрээнд заасан эрсдлээс бусад тохиолдолд ачаа саатсанаас болж учирсан хохирол;

16.14 Байгалийн гамшиг, даатгуулагчийн ажил мэргэжилтэй холбоогүй үйл ажиллагаа буюу даатгалын эрсдэлд хамаарахгүй үйл ажиллагаанаас гуравдагч этгээдэд учруулсан хохирол, түүний хариуцлага;

16.15 Тээврийн хэрэгслийн найдваргүй байдал, шаардлага хангаагүй тээврийн хэрэгслээр тээвэрлэснээс болж учирсан хохирол;

16.16 Даатгуулагч нь "Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо /МТЗНХ/" ТББ-ын 2016 оны 03 сарын 18-ны өдөр гаргасан Тээвэр зуучлалын үйлчилгээ зохион байгуулах ерөнхий нөхцлийн дагуу үйл ажиллагаа явуулаагүйгээс үүдсэн хохирол;

16.17 Даатгуулагчийн харилцагч буюу илгээгч нь ачааг илгээхдээ тээвэрлэж буй ачааны онцлогоос хамаарч сав, баглаа боодлыг зохих заавар, журмын дагуу хийгээгүйгээс үүдэн гарах хохирол;

17. НӨХӨН ТӨЛБӨРТ БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

17.1 Даатгуулагчийн хохирол нөхөн төлүүлэх тухай өргөдөл, албан бичиг;

17.2 Тээврийн баримтын хувь, тээврийн хөлсний нэхэмжлэхийн хуулбар;

17.3 Даатгалын тохиолдол бий болсныг нотлох фото зураг, боломжтой бол хэргийн газар дээрээс баталгаажуулсан нотлох баримтууд, эд мөрийн баримтууд;

17.4 Даатгалын зүйлийн хохирлын шалтгаан, хэмжээний талаарх мэргэжлийн байгууллагын хохирлын акт, дүгнэлт, тодорхойлолт, материал болон баримт; /Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын экспертийн дүгнэлт, Цагдаагийн газрын тодорхойлолт, ОБЕГазар, шүүх, прокурор, мөрдөн байцаах газар, холбогдох засаг захиргааны байгууллага болон хөндлөнгийн үнэлгээний байгууллагын дүгнэлт, акт гэх мэт/;

17.5 Тээвэрлэгч байгууллага болон тухайн тээвэрт хамтран ажилласан агентын тодорхойлолт;

17.6 Даатгагч шаардлагатай гэж үзсэн нэмэлт баримт, материалууд;

17.7 Барааны үнийн нэхэмжлэл, тоо ширхгийн мэдээлэл, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд даатгагч нь барааны нэхэмжлэх (commercial invoice)-г гаалийн тамга, тэмдэг дарагдсан байдлаар шаардана;

17.8 Учирсан хохиролтой холбоотой хохирогч болон ачаа хүлээн авагчийн өргөдөл, тодорхойлолт, шаардлагатай мэдээ, мэдээллүүд;

18. НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

18.1 “Осол” гэж аливаа хатуу биет даатгалын зүйлд гаднаас гэнэт, механик хүчээр үйлчилж, түүний даатгуулах үеийн хэлбэр, хэмжээ, шинж чанар, төлвийг өөрчлөх үйл явцыг хэлнэ;

18.2 “Барааны нэр төрөл” гэж олон улсын тээвэрлэлтэд хориглосон болон хасалтад заагдсанаас бусад бараанууд үүнээс ОХУ-аар тээвэрлэхийг хориглосон бараа бүтээгдэхүүн боловч шаардлагын дагуу тусгай лац ломботой тээвэрлэж байгаа ачаа бараанд хамаарахгүй;

18.3 “Тээвэрлэж буй ачаа” гэж даатгуулагчийн үйлчлүүлэгч, түүний импортлох болон экспортлох ачаа тээврийг;

18.4 “Тээвэрлэгдэж буй ачааны даатгалын хүчинтэй хугацаа” гэж тухайн ачаа тээвэрлэлтэд гарсан үеэс даатгалын хамгаалалт эхлэн эцсийн цэгт буюу хүлээн авагчийн эзэмшилд очсоноор даатгалын хамгаалалт дуусгавар болно;

18.5 “Даатгалын үйлчлэх хүрээ” гэж олон улсын ачаа тээврийн нэгдсэн хороо (JCC-Joint Cargo Committee)-с зарладаг жагсаалтад эрсдэл өндөр, илүү өндөр, онцгой өндөр, маш өндөр (high, very high, severe, extreme)

зэрэглэлийн эрсдэлтэй гэж тусгагдсан улс орнуудаас бусад улс орон руу ачаа тээвэрлэх болон ачаа тээвэрлэгдэн Монгол улс руу тээвэрлэх;

18.6 “Илгээгч” гэж даатгалын зүйлийг хүлээн авагч руу тээвэрлэлтийн нөхцөл шаардлагыг хангасан, аюулгүй ажиллагааны зааварчилгаанд заасан сав баглаа боодол, ачилт, бэхлэгээний шаардлага, нөхцөлийн дагуу зориулалтын, тохиромжтой сав, баглаа боодолтой байршуулах, хагарч, асгарч, муудаж чанарын шаардлага болон анх байсан төлөвөө алдахгүй байх зориулалтын, тохиромжтой сав баглаа боодолд хийн илгээж буй этгээдийг;

18.7 “Даатгалын сертификатаг” гэж жилийн гэрээний хувьд тээвэрлэлт бүрд тухайн даатгалын зүйл даатгалтайг баталсан, даатгагчаас олгогдох баримт бичгийг;

18.8 “Хүлээн авагч” гэж даатгалын зүйлийг илгээгчээс эцсийн цэгт буюу захиалгад заасан газарт хүлээн авч, ачаа хүлээлцэх акт (Delivery receipt)-ийг үйлдэх, мөн даатгагчид хохирлын талаар мэдээлэх этгээдийг;

18.9 “Хөндлөнгийн шинжээчийн тайлан (inspection survey report)” гэж ачаа барааг зөөвөрлөх тээврийн хэрэгсэлд ачуулахын яг өмнө болон дараах, ачаа барааг тээвэрлэгдэх явцын болон эцсийн цэгт хүргэгдэн ирсэн ачаа барааг хүлээн авах үеийн нөхцөл

18.10 “Олгохоор тооцсон нөхөн төлбөр” гэж даатгалын тохиолдлын улмаас даатгалын зүйлд учирсан хохирлыг даатгалын гэрээнд заасны дагуу даатгагчаас тооцоолж гаргасан нөхөн төлбөрийн хэмжээг;

18.11 “Өөрийн хүлээх хариуцлага” гэж даатгуулагч өөрт учирсан хохирлынхоо тодорхой хэсгийг өөрөө хариуцахыг;

18.12 “Ерөнхий дундаж (general average)” гэж далайн тээврийн үед тохиолддог бөгөөд тухайн ачаа бараанд үүссэн нөхцөл байдал нь бусад ачаа бараа болон хөлөг онгоцны аюулгүй байдалд заналхийлж байвал хөлгийн ахмад ерөнхий дунджийг зарлан, хамгийн ойр байрлах порт руу чиглэлийг өөрчилдөг. Үүнтэй холбоотойгоор үүссэн зардлыг хөлөг онгоц дээрх ачаа бараа эзэмшигч өмчлөгчид нийт хохирлын дүнд эзлэх өөрийн ачаа барааны хувийн жингээр хариуцлага хүлээх харилцааг;

18.13 “Ачааг хаях (jettison)” гэж тухайн ачаа бараа нь бусад ачаа бараа болон агаарын хөлөг, хөлөг онгоцны аюулгүй байдалд заналхийлж байвал тухайн онгоцны тэнцвэртэй байдлыг хангах зайлшгүй шаардлагаар ачаа барааг агаарын хөлөг, хөлөг онгоцноос хаяхыг;

18.14 “Нэг удаагийн тохиолдол” гэж нэг удаагийн тээвэрлэлтээр нэг тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэж байх үед ижил шалтгааны улмаас үүссэн ослоос үүдэн гарсан хохирлуудын нийлбэр;

¹ Энэхүү Хариуцлагын даатгалын хэсэг нь дангаараа гэрээний нөхцөл тул энэхүү хүснэгтийн бусад заалттай холбоогүй болно.